



АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/07.

Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх
арга хэмжээний тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 238 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 3728 тоот чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газраас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасантай холбогдуулан уг хугацаанд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс байгууллага дээр ажиллах албан хаагчдын нэрсийг нэгдүгээр хавсралтаар, “Коронавируст (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээний түр журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нэгдүгээр хавсралтад дурдсан албан хаагчдаас бусад албан хаагчдыг гэрээс нь цахимаар ажиллуулсугай.

3. Байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг тасралтгүй хэрэгжүүлж, шаардлагатай тохиолдолд ажлын байранд ажиллахыг бүх албан хаагч нарт даалгасугай.

4. Нийт албан хаагч нарт “Коронавируст (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээний түр журам”, Улсын онцгой комиссоос өгч байгаа Коронавируст (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг мөрдөж, хариуцлагатай ажиллахыг даалгасугай.

5. Ажлын байранд болон гэрээсээ цахимаар ажиллах албан хаагчдын цагийг бүртгэж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг бүх нэгжийн дарга нарт, цалин хөлсийг холбогдох хууль, журмын дагуу олгохыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Б.Дашпүрэв/-т даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэс баялгийн салбарын асуудал хариуцсан орлогч дарга /М.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

Хөтлөх хэргийн 4/1-д
Д.Билгүүн

Тушаал /A/ D:\SCAN FILES\2021 tushaal\үйл ажиллагаа

53700031

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
 2024 оны 04 дүгээр/ дугаар сарын 24.-ний/ны өдрийн
 №04 дугаар /дүгээр/ тушаалын нэгдүгээр хавсралт

ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААНД
 БАЙГУУЛЛАГА ДЭЭР АЖИЛЛАХ АЛБАН ХААГЧДЫН НЭРС

Д/д	Харьяалах хэлтэс	Ажиллах огноо	Овог, нэр	Утасны дугаар
1	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Даваа	Б.Дашпүрэв Б.Алтан-Очир Д.Дарьхүү Ө.Давааням Х.Чулуунцэцэг Т.Батчимэг Т.Болорцэцэг Г.Ариунтунгалаг Д.Эрдэнэчимэг Э.Дуламсүрэн П.Болормаа Д.Өлзийсайхан Ж.Доржсүрэн С.Байгальмаа	99093203 96005742 99991994 88104975 99003545 96017337 99070737 99021447 99033281 99102883 99002066 99001933 94792923 99004757
		Мягмар	Б.Дашпүрэв Ш.Маргад Б.Отгонтуяа Ө.Давааням У.Цэвэлмаа Ч.Хандсүрэн Ч.Наранцэцэг С.Манлайдулам Д.Өлзийсайхан Д.Билгүүн	99093203 99117608 88626483 88104975 99151442 99160069 99090267 99002808 99001933 99639963
		Лхагва	Б.Дашпүрэв Б.Алтан-Очир Д.Дарьхүү Ө.Давааням С.Байгальмаа Х.Чулуунцэцэг Д.Эрдэнэчимэг Т.Батчимэг Ө.Номин-Эрдэнэ Б.Оюун Б.Болормаа Ж.Доржсүрэн	99093203 96005742 99991994 88104975 99004757 99003545 99033281 96017337 97007717 99049333 99001995 94792923
		Пүрэв	Б.Дашпүрэв Ш.Маргад П.Бэхтогтох Б.Отгонтуяа Д.Билгүүн	99093203 99117608 89521726 88626483 99639963

			Э.Дуламсүрэн Т.Болорцэцэг Г.Ариунтунгалаг М.Урансолонго У.Цэвэлмаа Э.Дуламсүрэн Б.Болормаа	99102883 99070737 99021447 88888008 99151442 99102883 99001995
		Баасан	Б.Дашпүрэв Б.Алтан-Очир Д.Дарьхүү П.Бэхтогтох Т.Батчимэг С.Янжинлхам Д.Эрдэнэчимэг Х.Чулуунцэцэг Ч.Наранцэцэг С.Манлайдулам Ж.Доржсүрэн С.Байгальмаа Д.Билгүүн	99093203 96005742 99991994 89521726 96017337 99990041 99033281 99003545 99090267 99002808 94792923 99004757 99639963
2	Уул уурхай, судалгааны хэлтэс	Даваа	С.Энхболд Ц.Өнөрнасан Д.Мөнхсайхан Д.Сагараадорж Э.Мөнгөнхүү П.Золзаяа Б.Хулан	99113467 88035087 99061708 99039938 99021564 99964995 99777000
		Мягмар	С.Энхболд Ц.Өнөрнасан Х.Лхагвабаатар Д.Маасүрэн Ц.Золзаяа Г.Дөл	99113467 88035087 99041028 99191314 99009962 99107564
		Лхагва	С.Энхболд Ц.Цэгц Д.Маасүрэн П.Золзаяа Д.Мөнхсайхан Д.Сагараадорж	99113467 99880212 99191314 99964995 99061708 99039938
		Пүрэв	С.Энхболд С.Баттулга Х.Лхагвабаатар Д.Эрдэнэтунгалаг Д.Сэрээтэр Г.Дөл	99113467 99110933 99041028 99054323 99902277 99107564
		Баасан	С.Энхболд Ц.Цэгц Ц.Золзаяа	99113467 99880212 99009962

			Б.Хулан Д.Сэрээтэр Э.Мөнгөнхүү	99777000 99902277 99021564
3	Хууль, эрх зүйн хэлтэс	Даваа	Р.Энхтайван Э.Баттөр Ц.Жавхлан	99095045 88101179 99026969
		Мягмар	Р.Энхтайван С.Дашдаржаа Ч.Амгалан	99095045 98982888 91911291
		Лхагва	Р.Энхтайван Ч.Эрхэмбаяр Ч.Амгалан Ц.Жавхлан	99095045 99990643 91911291 99026969
		Пүрэв	Р.Энхтайван С.Дашдаржаа Ч.Эрхэмбаяр Г.Эрдэнэболд	99095045 98982888 99990643 99104052
		Баасан	Р.Энхтайван Э.Баттөр Г.Эрдэнэболд	99095045 88101179 99104052
4	Геологи, уул уурхайн кадастрын хэлтэс	Даваа	Д.Батмагнай Б.Тамир Н.Наранцацрал Э.Амартөвшин У.Сүхбаатар А.Батгэрэл Ц.Баатарбилэг Т.Оюунтунгалаг Э.Баттогтох	99096757 99111021 99000197 99721612 88110077 99378915 91919702 99771977 99007776
		Мягмар	Д.Батмагнай Т.Хатанбаатар Д.Одончимэг А.Нямдорж Ш.Мандахжаргал Б.Батсайхан Д.Мягмарсүрэн Ч.Золзаяа Н.Хэрлэнчимэг	99096757 99194923 91919010 99174717 99007341 91111151 99003696 99000164 96657722
		Лхагва	Д.Батмагнай Б.Тамир У.Сүхбаатар Н.Наранцацрал Э.Амартөвшин Т.Оюунтунгалаг А.Батгэрэл Н.Отгонсүрэн Э.Баттогтох	99096757 99111021 88110077 99000197 99721612 99771977 99378915 99100349 99007776

		Пүрэв	Д.Батмагнай Д.Одончимэг Т.Хатанбаатар Н.Наранцацрал Н.Хэрлэнчимэг Д.Мягмарсүрэн Б.Батсайхан Ц.Баатарбилэг Ч.Золзаяа	99096757 91919010 99194923 99000197 96657722 99003696 91111151 91919702 99000164
		Баасан	Д.Батмагнай Б.Тамир Т.Хатанбаатар У.Сүхбаатар Ш.Мандахжаргал Э.Баттогтох Н.Отгонсүрэн Д.Мягмарсүрэн А.Нямдорж	99096757 99111021 99194923 88110077 99007341 99007776 99100349 99003696 99174717
5	Нүүрс, судалгааны хэлтэс	Даваа	М.Мэндбаяр С.Пүрэвжал Т.Пүрэвцэнд	99091539 96282048 99086254
		Мягмар	М.Мэндбаяр Б.Алтсүх Г.Төрмөнх	99091539 99031160 99886088
		Лхагва	М.Мэндбаяр С.Пүрэвжал Г.Төрмөнх	99091539 96282048 99886088
		Пүрэв	М.Мэндбаяр Э.Мөнхзориг Т.Пүрэвцэнд	99091539 99033158 99086254
		Баасан	М.Мэндбаяр Э.Мөнхзориг Т.Пүрэвцэнд	99091539 99033158 99086254
6	Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс	Даваа	Н.Энхцогт Д.Дагвасүрэн Д.Цэнд-Аюуш	99110857 88017383 88098098
		Мягмар	Д.Дагвасүрэн Г.Жандаулет Б.Эрдэнэчулуун	88017383 95426666 99097457
		Лхагва	Д.Цэнд-Аюуш О.Гарамханд Г.Жандаулет	88098098 80875566 95426666
		Пүрэв	Д.Цэнд-Аюуш Б.Энхтүвшин Г.Жандаулет	88098098 99176715 95426666
		Баасан	Д.Дагвасүрэн О.Баярмаа	88017383 88051199

			Б.Манзушир	99775548
7	Газрын тосны ашиглалтын хэлтэс	Даваа	С.Пүрэвжав М.Айдын Д.Пүрэвбат Г.Пүрэвринчин	99096213 95738426 99165590 80242324
		Мягмар	С.Пүрэвжав М.Айдын М.Батдэлгэр Э.Батзолбоо	99096213 95738426 95959293 99733637
		Лхагва	С.Пүрэвжав М.Айдын Р.Наранбаатар Ш.Баяндүүрэн	99096213 95738426 99103476 89048487
		Пүрэв	С.Пүрэвжав М.Айдын А.Ёндонсүрэн Ш.Баяндүүрэн	99096213 95738426 99184377 89048487
		Баасан	С.Пүрэвжав М.Айдын Д.Пүрэвбат Г.Пүрэвринчин	99096213 95738426 99165590 80242324
8	Хүнд үйлдвэр, судалгаа, техник, технологийн хэлтэс	Даваа	Х.Анар Т.Хоролсүрэн	99039698 91119877
		Мягмар	Х.Анар Ц.Жаргалнэмэх	99039698 99999699
		Лхагва	Х.Анар П.Оюунтуяа	99039698 99913939
		Пүрэв	Х.Анар Ц.Жаргалнэмэх	99039698 99999699
		Баасан	Х.Анар П.Оюунтуяа	99039698 99913939
9	Уул уурхай, газрын тосны төв лаборатори	Даваа	Г.Оюунтуяа Д.Ууганчимэг Ч.Навчаа	99080016 88056764 88605287
		Мягмар	Г.Оюунтуяа Ж.Бадамсүрэн У.Солонго	99080016 88010925 99880710
		Лхагва	Г.Оюунтуяа Д.Ууганчимэг Ч.Навчаа	99080016 88056764 88605287
		Пүрэв	Г.Оюунтуяа Ж.Бадамсүрэн У.Солонго	99080016 88010925 99880710
		Баасан	Г.Оюунтуяа Д.Ууганчимэг Ч.Навчаа	99080016 88056764 88605287

10	Газрын тосны хайгуулын хэлтэс	Даваа	Б.Сүнжидмаа Б.Золбообаяр З.Цогтбаяр Д.Чинзориг	99093797 99901531 99171503 99003728
		Мягмар	Б.Сүнжидмаа Б.Золбообаяр С.Пүрэвсүрэн А.Түвшинжаргал	99093797 99901531 99000661 99098531
		Лхагва	Б.Сүнжидмаа Б.Золбообаяр Ч.Магнайбаяр	99093797 99901531 99777060
		Пүрэв	Б.Сүнжидмаа Б.Золбообаяр Д.Цэрэнханд С.Дэмбэрэл	99093797 99901531 99058735 91455555
		Баасан	Б.Сүнжидмаа Б.Золбообаяр Т.Батхишиг Л.Мөнгөнтөгс	99093797 99901531 91008182 88082894
11	Ашигт малтмалын хайгуулын хэлтэс	Даваа	Ү.Ганбаатар А.Тамираа	88114746 99254340
		Мягмар	Ү.Ганбаатар М.Мөнгөнтуяа	88114746 99019103
		Лхагва	Ү.Ганбаатар Т.Батдорж	88114746 99001757
		Пүрэв	Ү.Ганбаатар Б.Мөнх-Эрдэнэ	88114746 99002660
		Баасан	Ү.Ганбаатар Б.Үүрийнцолмон	88114746 99900156
12	Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэс	Даваа	Б.Буянзаяа М.Мөнхзул	94001727 99183150
		Мягмар	Б.Буянзаяа Ц.Содцэцэг	94001727 99005116
		Лхагва	Б.Буянзаяа М.Мөнхзул	94001727 99183150
		Пүрэв	Б.Буянзаяа Л.Бадамханд	94001727 99097050
		Баасан	Б.Буянзаяа С.Оюун-Эрдэнэ	94001727 99001038

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
2020 оны 07 дүгээр /дугаар сарын 07/-ний/ны өдрийн
07 дугаар /дүгээр/ тушаалын хоёрдугаар хавсралт

КОРОНАВИРУСТ (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ ИЛЭРСЭН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТҮР ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын бэлэн байдлыг хангаж, болзошгүй эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулахад оршино.
- 1.2 Улсын онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 3728 тоот чиглэлийн дагуу ажлын байранд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээг зохицуулна.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА

- 2.1 Тус газрын удирдлага, бүх нэгжийн дарга, ажилтан, албан хаагчид дагаж мөрдөх бөгөөд гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг бууруулах болон цуцлагдах хүртэл энэхүү түр журмыг дагаж мөрдөнө.

ГУРАВ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

- 3.1 Ажилтан, албан хаагчдыг ажилдаа ирэх үед зайнаас халуун хэмжигч багажаар шалгаж, асуумж хуудсыг бөглүүлж, гарыг ариутгуулж, амны хаалтыг зүүлгэж, ариутгагч халдваргүйжүүлэгч хаалгаар ариутгаж нэвтрүүлж байх. /амны хаалтгүй, халдвар хамгааллын дэглэм зөрчсөн, коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын сэжигтэй шинж тэмдэг илэрсэн, биеийн халуун 37 хэмээс дээш ажилтан, албан хаагчийг нэвтрүүлэхгүй гэрт нь буцаах, эрүүл мэндийн байгууллагад хандахыг зөвлөх/
- 3.2 Байгууллагад гаднаас иргэдийг нэвтрүүлэхгүйгээр халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж, хэвийн тохиолдолд Ebarimt аппликейшнээр бүртгэлийн цэг QR-кодыг уншуулж, шалган нэвтрүүлэх үүдний хэсэгт нэг цонхоор хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдтэй холбогдох нэгжийн ажилтан, албан хаагчийг дуудаж уулзуулах.
- 3.3 Ажлын байранд нийт ажилтан, албан хаагчид амны хаалтыг тогтмол зүүж хэрэглэх /2 цаг тутамд солих/, хэрэглэгч, харилцагчдад үйлчилгээ үзүүлж буй ажилтан, албан хаагч нэг удаагийн бээлий, нүүрний хаалт зүүж ажиллах, гарыг бохирдсон тухай бүр савандаж угаах, спиртийн суурьтай халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйжүүлэх, бусадтай гар барихгүй байх.
- 3.4 Өдрийн хоол болон бусад цагуудад олноороо нэг дор цугларч бөөгнөрөл үүсгэхгүй байх, хэт ойроос харьцахгүй хүн хоорондын зайг 2 метрээс багагүй байлгах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, онцын шаардлагагүй тохиолдолд гадуур гарах, нийтийн хоолны газраар үйлчлүүлэхээс татгалзах.

3.5 Хоёроос олон хүн цуглаж, хурал, сургалт, уулзалт хийхээс зайлсхийж, онлайн уулзалт, хурал, сургалтыг зохион байгуулах.

3.6 Тус байрны нийтийн эзэмшлийн талбай, үүд, давхруудын коридор болон албан хаагчдын өрөө тасалгаанд тогтмол агаар сэлгэлт хийх, цэвэрлэгээ, үйлчилгээг өдөр бүр тогтмол 1 удаа чийгтэй цэвэрлэгээ хийх, мөн вирусийн эсрэг үйлчилгээтэй бодисоор ариутгал, халдваргүйжүүлэлтийг 7 хоногт 1 удаа батлагдсан стандартын дагуу чанартай хийлгүүлэх, гар байнга хүрдэг хаалга, шатны бариул, компьютерын гар, хулгана, суурин утас зэрэг өдөр тутамд хэрэглэгддэг тоног төхөөрөмжийг ариутгалын бодисоор ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх. */засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар хариуцан гүйцэтгэх/*

3.7 Коронавируст халдвар (Ковид-19)-ын халдвараас урьдчилан сэргийлэх санамж, заавар, зөвлөмжийг байгууллагын албан ёсны веб сайт, пэйж хуудас үйлчилгээний танхим, албан тасалгаа, давхруудын коридор, мэдээллийн самбарт тогтмол байршуулж, сурталчлах.

3.8 Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор амны хаалт, нэг удаагийн бээлий, гар халдваргүйжүүлэх спиртийн суурьтай бодис, халдвар хамгааллын хувцас зэргийг нөөц бүрдүүлэн ажиллах.

3.9 Ажилтан, албан хаагчдын ариун цэврийн өрөөнд гар угаах нөхцөлийг бүрдүүлж, гарын шингэн саван, халдваргүйжүүлэх уусмалыг хүрэлцэхүйц хэмжээгээр байршуулж, тогтмол цэнэглэж байх.

3.10 Ажилтан, албан хаагч нэг бүр өөрийн эрүүл мэндийн байдалдаа онцгой анхаарч, дархлаагаа дэмжиж, коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар эрүүл мэндийн байгууллагын өгч байгаа санамж, зөвлөгөөг мөрдөж өдөр тутамдаа хэрэгжүүлэх.

3.11 Ажил үүргээ гэрээсээ гүйцэтгэх тушаал шийдвэр гарсан тохиолдолд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр хугацаанд нь чанартай хийж, гүйцэтгэх, өдөр бүр ажлын явц, үр дүнг шууд удирдлагад тайлагнах, шаардлагатай тохиолдолд ажлын байранд ирж ажиллах, оршин суугаа газраас өөр тийшээ, явахгүй байх, гар утсаа нээлттэй байлгаж утасны дуудлагад тухай бүр хариу өгөх.

3.12 Өөрийн явсан зам маршрут, уулзсан хүний тухай өдөр бүр тэмдэглэл хөтлөх.

3.13 Ажлын бус цагаар албан хаагчдыг нэвтрүүлэхгүй бөгөөд зайлшгүй шаардлагатай тохиолдолд холбогдох нэгжийн даргаар дамжуулан Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргаас зөвшөөрөл авч нэвтрүүлэх.

ДӨРӨВ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРСЭН ТОХИОЛДОЛД АНХААРАХ ЗҮЙЛС

4.1 Сүүлийн 14 хоногийн хугацаанд онош батлагдсан хүнтэй ойрын хавьтал болсон, халуурах, хуурай ханиалгах, ядарч сульдах, цэр гарах, амьсгал давчдах, булчин, хоолой, толгой өвдөх, суулгах, хамар битүүрэх зэрэг шинж тэмдгийн аль нэг нь илэрсэн хүнийг сэжигтэй тохиолдол гэж үзэх

4.2 Ажилтан, албан хаагч ажлаа хийж байх явцад дээрх сэжигтэй тохиолдлын шинж тэмдэг илэрвэл:

4.2.1 Сэжигтэй тохиолдлын мэдээлэл авмагц томилогдсон эрүүл мэнд, анхны тусламжийн бүлэг тусгаарлах өрөөнөөс амны хаалт, нэг удаагийн халдвар

хамгааллын хувцас, бээлий, улавч өмсөж тухайн хүнийг урьдчилан бэлтгэсэн тусгаарлах өрөөнд хүргэх.

4.2.2 Сэжигтэй тохиолдлын шинжилгээний хариу гартал тусгаарлах өрөөг битүүмжлэх эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг дагана.

4.2.3 Сэжигтэй тохиолдлын онош батлагдсан тохиолдолд голомтод зоонозын өвчин судлалын үндэсний төвийн бэлтгэгдсэн халдваргүйжүүлэлтийн баг ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх.

4.2.4 Нийт ажилтан, албан хаагчид айж, сандрахгүй, тайван байж халдвар хамгааллын дэглэмийг сайтар мөрдөж, дүрэм журмыг баримталж ажиллах.

4.3 Ажилтан гэртээ байх үед болон ажилтны гэр бүлийн гишүүд сэжигтэй тохиолдлын шинж тэмдэг илэрвэл:

4.3.1 Ажилтан гэртээ байх хугацаанд өөрт эсвэл гэр бүлийн гишүүнд 4.1-д дурдсан шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдах албан тушаалтан болон ХӨСҮТ -100, 80086829, ЗӨСҮТ-70284393, СЭМҮТ-1800-2000, ЭМЯ-11-323002 дугаарын утсанд мэдэгдэж ажилдаа ирэлгүй гэртээ өөрийгөө тусгаарлах арга хэмжээ авах.

4.3.2 Гэрийн тусгаарлалтад байгаа сэжигтэй тохиолдол нь гэрээсээ гарахгүй, гэртээ зочин урихгүй байж, гэр бүлийн бусад гишүүдээс аль болох зай барихыг хичээж, хоол хүнс, ахуйн хэрэглээний зүйлс, аяга тавгийг тусдаа хэрэглэх, 3 цаг тутамд халуунаа хэмжиж, эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг баримтлах.

ТАВ. ТҮР ТУСГААРЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

5.1 Албан хаагчдад халуурах, хуурай ханиалгах, хоолой өвдөх, амт үнэр мэдрэхгүй болох, нус гоожих, гүйлгэх зэрэг шинж тэмдэг илэрвэл өрөөнөөсөө гаралгүйгээр АМГТГ-ын Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн 99006556, 51-263750, 94001727 дугаарын утсаар мэдээлнэ.

5.2 АМГТГ-ын Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиас сэжигтэй тохиолдол илэрсэн тухай мэдээллийг хүлээн авсан даруйд мэргэжил, арга зүйгээр ханган, мэдээллийг ХӨСҮТ-ийн 100 болон 80086829 дугаарын утсанд мэдээлнэ.

5.3 АМГТГ-ыг Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиас “Шүтээн уул” харуул хамгаалалтын албаны 88082687, 51-263741 Лабораторийн 99080016, 93065006, 70188122 дугаарын утсанд мэдэгдэж, байрнаас орох гарах хөдөлгөөнийг хориглох, албан хаагчдад өрөөнөөсөө гарахгүй байхыг анхааруулж, хяналт тавих арга хэмжээг авна.

5.4 Нийт албан хаагчдадаа холбоо зарлан мэдээлэл хариуцсан ажилтан, зарлан мэдээлэх бүлэг хамтран зарлан мэдээлэл дамжуулах схемийн дагуу мэдээллийг цахим дотоод сүлжээ болон утсаар шуурхай дамжуулна.

5.5 Төв байрны 4 дүгээр давхрын 400А тоот өрөө, Уул уурхай, газрын тосны төв лабораторийн 2 давхрын 207 тоот өрөөнүүдийг түр тусгаарлах өрөө болгон, бэлэн байдлыг засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газартай хамтран хангалт хариуцсан ажилтан хариуцаж, МХЕГ-ын шуурхай штаб мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

5.6 Түр тусгаарлах өрөөнд гар халдваргүйжүүлэгч, амны хаалт, нэг удаагийн бээлий, нэг удаагийн халдвар хамгааллын хувцас, халуун хэмжигч, нойтон салфетка, нэг удаагийн аяга, халбага, ус буцалгагч, савласан цэвэр ус, хогийн уут, хөлөөр

онгойдог тагтай хогийн сав зэргийг байлгаж, тусгаарлах өрөөнөөс орж гарахгүй байх, халдвар хамгааллын дэглэм мөрдөхийг анхааруулсан санамжийг тус тус байрлуулна.

5.7 Түр тусгаарлах өрөөний түлхүүр, түр тусгаарлах өрөөг хааж, бүс тогтоох тэмдэг тэмдэглэгээ, хаалтыг харуул хамгаалалтын албан хаагч дээр бэлэн байлгана.

5.8 Сэжигтэй тохиолдол гэж үзсэн албан хаагч өрөөндөө ганцаар ажилладаг бол өрөөнд нь, өөр албан хаагчтай хамт нэг өрөөнд ажилладаг бол сэжигтэй тохиолдлыг төв байрны коридорын зүүн талын шатаар дээш өгсөж, 4 давхрын 400А тоот өрөөнд болон Уул уурхай, газрын тосны төв лабораторийн 2 давхрын 207 тоот тусгаарлах өрөөнд тусгаарлаж тэмдэг, тэмдэглэгээ ашиглан хаалт хийж бүс тогтооно.

5.9 Сэжигтэй тохиолдолтой хамт нэг өрөөнд байсан алба хаагчид биеийн халуунаа өөрсдөө үзэж биеийн халуун нь 37 хэмээс доош, халдварын шинж тэмдэг илрээгүй тохиолдолд халдвар хамгааллын дэглэм баримталж амны хаалтыг тогтмол солин, сэжигтэй тохиолдлын PCR буюу ПГУ /полимеразын гинжин урвал/-ын шинжилгээний хариу гарах хүртэл хугацаанд өрөөндөө тусгаарлагдана.

5.10 Түр тусгаарлах өрөөнд тусгаарлагдсан албан хаагч түр тусгаарлах өрөөтэй ойрхон ариун цэврийн өрөөг ашиглана.

5.11 Сэжигтэй тохиолдлын болон ойрын хавьтлуудын PCR буюу ПГУ /полимеразын гинжин урвал/-ын шинжилгээний хариу эерэг гарвал мэргэжлийн байгууллагуудын шийдвэр, холбогдох журмын дагуу дараагийн үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

5.12 PCR буюу ПГУ /полимеразын гинжин урвал/-ын шинжилгээний хариу эерэг гарсан албан хаагчийг халдвар хамгааллын дэглэмийг баримталж, төв байрны тусгаарлах өрөөнөөс коридорын зүүн шатаар доош буулгаж төв хаалгаар, мөн Уул уурхай газрын тосны төв лабораторийн тусгаарлах өрөөнөөс шатаар доош буулгаж төв хаалгаар гадагш гаргана.

5.13 PCR буюу ПГУ /полимеразын гинжин урвал/-ын шинжилгээний хариу эерэг гарсан албан хаагчийн ажлын өрөө, түр тусгаарлах өрөө, ариун цэврийн өрөөний хог хаягдлыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай” 505 дугаар тушаалын дагуу голомтын халдваргүйжүүлэлт хийсэн байгууллагад өгч устгуулна.

5.14 Сэжигтэй тохиолдлын болон ойрын хавьтлуудын PCR буюу ПГУ /полимеразын гинжин урвал/-ын шинжилгээний хариу сөрөг гарвал мэргэжлийн байгууллагын шийдвэрээр ажлын хэвийн горимд шилжинэ.

5.15 Ажлын цагаар байрнаас түр гарсан албан хаагчид эмнэл зүйн шинж тэмдэг болон түргэвчилсэн тестээр эерэг гарсан тохиолдолд байгууллагын шуурхай штабт мэдэгдэж, PCR буюу ПГУ /полимеразын гинжин урвал/-ын шинжилгээний хариу гартал энэхүү журмын дагуу ажлын байранд авах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.16 Тухайн өдөр ажлын байранд байхгүй боловч өмнөх өдөр ажилласан болон байрнаас түр гарсан албан хаагч, үйлчлүүлсэн бусад хүмүүст шинжилгээний хариу гартал гэрээсээ гарахгүй, өөрийгөө тусгаарлаж ажиглах зөвлөмжийг албан хаагч бүр дагаж мөрдөнө.

5.17 Тус байранд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдол илэрсэн үед авах арга хэмжээг зөрчсөн тохиолдолд байгууллагын дотоод журам болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.